



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/216

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулж, газар  
эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын санал, иргэний хүсэлтийг үндэслэн сумын Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/65 дугаар захирамжийн хавсралтын 11 дэх заалтаар Сандагдоржийн Цэрэндолгор (РЖ76040328)-т Мөрөн сумын 8 дугаар баг 4-н зам “Бишрэлт” ХҮТөв худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттайгаар эзэмшүүлсэн газрын талбайн хэмжээг 526м2 гэснийг 762м2 гэж өөрчилж газар эзэмшүүлэх хугацааг 40 жилээр сунган эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2010 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/65 дугаар захирамжийн хавсралтын 11 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч С.Цэрэндолгор (РЖ76040328)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-т, Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН